

Хүчин төгөлдөр хугацааны талаарх танилцуулга

Тэтгэврийн мөнгө авах эрх үүссэн өдөр (Жишээ нь: Хилээр гарсан өдөр, тэтгэвэр авах насанд хүрсэн өдөр)-өөс хойш 5 жилийн дотор нэхэмжлэл гаргахгүй бол нэхэмжлэл гаргах хугацаа дууссан гэж үзээд тэтгэвэр олгогдохгүй.

Цахим шуудангаар үйлчилгээ авах хүсэлт гаргах тухай

Цахим шуудангийн үйлчилгээний хүсэлт гаргасан бол Үндэсний тэтгэврийн даатгал олгогдох нөхцөл бүрдсэн үед нэхэмжлэл гаргах тухай зааварчилгааг e-мэйлээр хүлээн авах боломжтой.

Хувь хүний мэдээлэл болон гэрийн хаяг өөрчлөлтийг мэдээлэх

Гадаадын иргэний үнэмлэхийн дугаар болон оршин суух эрх буюу визний төрөл өөрчлөгдсөн, Солонгосын иргэний харьяалтай болох ба иргэний харьяалалаа алдах(иргэншлээ сольсон), гадаад иргэншилтэй солонгос хүн Солонгос улсад оршин суух мэдүүлэг өгсөн, Солонгос дахь гэрийн хаяг утасны дугаараа өөрчилсөн тохиолдолд хамгийн ойр салбар буюу дуудлагын төвд(бүсийн кодгүй 1355) мэдэгдэх ёстой.

ГАДААД ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ҮНДЭСНИЙ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Guide to the National Pension for Foreigners

Гадаадын иргэдэд зориулсан үйлчилгээ

☎ **Гадаадын иргэдэд зориулсан дуудлагын төв**
02. 2176. 8700

Хятад хэл 02. 2176. 8735

Тайланд хэл 02. 2176. 8730

Индонез хэл 02. 2176. 8734

ээр зөвлөгөө өгч байна.

☎ **Ансан гадаадын иргэдэд зориулсан зөвлөгөө өгөх төв**

031. 365. 3082~3, 3086, 3087, 3089

Хятад, Индонез, Филиппин, Узбек, Орос хэл дээр зөвлөгөө авах боломжтой.

Хаяг : Кёнги аймаг, Ансан хот, Данвон дүүрэг, Шингиллу 1кил 10, Ворлд тауэрийн 1 давхар

🌐 **Тэтгэврийн даатгалын олон хэл дээрх сайт**

www.nps.or.kr

Англи, Хятад, Индонези, Монгол хэл



ГАДААД ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ҮНДЭСНИЙ ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Guide to the National Pension for Foreigners



Үндэсний тэтгэврийн тогтолцоо гэж юу вэ

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг зохих журмын дагуу төлснөөр, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, нас барсан тохиолдолд гэр бүлийнхэнд нь тэтгэвэр тэтгэмж олгож, амьжиргааны тогтвортой байдлыг хангах улсын нийгэм хамгааллын тогтолцоо юм.

Үндэсний тэтгэврийн даатгалд заавал даатгуулагч

Солонгос улсад оршин суугч 18-60 насны гадаадын иргэн Солонгос иргэдийн нэгэн адил Үндэсний тэтгэврийн даатгалд албан ёсоор хамрагдах боломжтой. Зөвхөн Солонгос иргэдийг өөрийн улсын тэтгэврийн тогтолцоонд хамруулдаггүй улсын иргэдэд хамрагдахгүй.

Түүнчлэн тухайн гадаад иргэний харъяат улс, БНСУ-тай нийгмийн хамгааллын гэрээ байгуулахдаа дээрх заалтаас өөр нөхцлийн оруулсан тохиолдолд тухайн гэрээний заалтыг мөрдөнө.

Тэтгэврийн даатгалын шимтгэл

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчын сарын орлогын 9%-тай тэнцэх мөнгөн дүнг ажил эрхлэгч болон ажил олгогч тус бүр 4.5%-иар хувааж төлнө.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч нь сарын бодит орлогын 9 хувьтай тэнцэх шимтгэл төлнө.

* Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээ нь Солонгос иргэдийн адил байх бөгөөд шимтгэлийг дараа сарын 10-ны дотор төлөх ёстой.

Тэтгэвэр тэтгэмж

Тэтгэврийн даатгал төлж буй гадаадын иргэд өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсан болон тэжээгчээ алдсаны тэтгэмжийг Солонгос иргэнтэй адил хэмжээгээр авна.

* Бүх төрлийн тэтгэврийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл ба нөхцөл шаардлагын тухай мэдээллийг Гадаад иргэдэд зориулсан зөвлөгөө өгөх үйлчилгээний төв, Лавлах төв(1355) болон хамгийн ойрхон байрлах салбараас лавлана уу.

Зарчмын хувьд гадаад иргэн нэг удаагийн буцаан олголтод хамрагддаггүй. Гэхдээ дараах 3 нөхцлийн аль нэгийг хангасан тохиолдолд буюу эх орондоо буцах, нас барах, тэтгэврийн насанд хүрэх үед нийт төлсөн даатгалын шимтгэл дээрээ тодорхой хэмжээний хүүг тооцон нэмсэн дүнгээр нэг удаагийн буцаан олголт хийгдэнэ

1 БНСУ-тай нийгмийн хамгааллын гэрээ байгуулсан улсын иргэд

Герман, Америк, Канад, Унгар, Франц, Австрали, Чех, Бельги, Польш, Словак, Болгар, Румын, Австри, Энэтхэг, Турк, Швед, Бразил

2 Засгийн газар нь Солонгосын иргэдэд нэг удаагийн буцаан олголт өгөхийг зөвшөөрдөг улсын иргэд

Даатгалд хамрагдсан доод хугацаа 6 сар

Белиз

Даатгалд хамрагдсан доод хугацаа 1 жил

Гренада, Иордан, Сент-Винсент ба Гренадин, Зимбабе, Камерун, Тайланд, Бутан

Даатгалд хамрагдсан доод хугацаа хамаарахгүй

Гана, Шриланка, Вермуда, Малайз, Швецари, Эльсалвадор, Индонез, Кения, Казакстан, Хонконг, Тренадотабако, Турк, Судан, Энэтхэг, Колумби, Вануату, Филиппин, Тунис, Уганда,

* Хамгийн бага хугацаагаар даатгалд хамрагдсан улс нь дээр дурдсан нөхцлийн хангасан тохиолдолд мөнгө нэхэмжлэх эрхтэй болно.

3 Сургалт дадлагын хөдөлмөр эрхлэлт(Е-8), гэрээт ажилчин (Е-9), ажиллах зорилготой зорчих (Н-2) визтэй гадаадын хөдөлмөр эрхлэгчид

* Үйлдвэрлэлийн дадлага хөдөлмөр эрхлэх (Е-8) статусын оршин суух эрхийг хүчингүй болгох тухай (2010.10.1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн)

Төлбөрийн нэхэмжлэл гаргахад бүрдүүлэх материал

Солонгост нэхэмжлэхэд (Эх орондоо буцахын өмнө)

Нэхэмжлэл, гадаад паспорт, гадаад иргэний үнэмлэх, Монгол дахь банкны дэвтрийн хуулбар, нисэх болон усан онгоцны тийзийн хуулбар.



Нисэх онгоцны буудлын төлбөр барагдуулах үйлчилгээ

Бүртгүүлэх эрх бүхий этгээд: Инчоны нисэх онгоцны буудлаар дамжин 1 сарын дотор эх орон руугаа буцах гэж байгаагаа тодорхойлсон гадаадын иргэн

Нэхэмжлэл гаргах арга: Нутаг буцахын өмнө хамгийн ойр байрлах тэтгэврийн даатгалын албаны салбар дээр биеэр очиж, нэг удаагийн буцаан олголтын нэхэмжлэл гаргахдаа нисэх онгоцны буудлын буцаан олголтын үйлчилгээгээр дамжуулан авах тухай хүсэлт гаргана.

Гадаад иргэний хувьд хилээр гарсан нь баталгаажсаны дараа нэг удаагийн буцаан олголт хийгддэг тул нисэх онгоцны буудлын буцаан олголтын үйлчилгээгээр дамжуулан авах хүсэлт гаргавал, хилээр буцаан олгогдоно.

Эх орноосоо шуудангаар нэхэмжлэхэд (Эх орондоо буцсаны дараа)

Нэхэмжлэл, оршин суугаа харъяат улсын нотариат, Солонгосын ЭСЯ-ны цохолт, гадаад паспортын хуулбар, нэхэмжлэгчийн банкны дэвтрийн хуулбар

Өөрийн улсын Нийгмийн н даатгалын газраар дамжуулан нэхэмжлэх

- **Бүрдүүлэх материал** : Нэхэмжлэлийн хуудас, гадаад паспортны хуулбар, банкны дэвтрийн хуулбар
- **Хамрагдах улс** : Монгол, Укбекстан, Тайланд, Шириланк, Киргизстан, Индонез

Оршин суугаа газраасаа олон улсын мөнгөн ээр гуйвуулгаар нэхэмжлэл гаргах тохиолдолд нэмэлтээр бүрдүүлэх материал: Гадаадруу мөнгөн гуйвуулга хийх өргөдлийн хуудас, банкны дэвтрийн гүйлгээ зэрэг өөрийн эзэмшлийн дэвтэр мөн болохыг батлах баримт бичиг